

# Management effectiveness evaluation of protected areas in the western region

Enkhchimeg Tsedensodnom<sup>1,\*</sup>, Udval Bayarsaikhan<sup>1</sup>, Batsaikhan Ganbaatar<sup>1</sup>,  
Batdorj Dovdondemberel<sup>1</sup>, Bayartulga Altankhuyag<sup>1</sup>

<sup>1</sup>*Division of Forest Resources and Forest Protection, Institute of Geography and Geoecology, Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia*

\*Corresponding author email: [enkhchimegts@mas.ac.mn](mailto:enkhchimegts@mas.ac.mn)

Received: 31 October 2022 / Accepted: 30 November 2022 / Published online: 29 December 2022

## ABSTRACT

We conducted a baseline assessment of management effectiveness in the state and local protected areas, where Phase 1 of the Biodiversity and Adaptation to Climate Change Project was implemented, using the “Management Effectiveness Tracking Tool” (METT), approved by Order No. A/374 of the Minister of Environment and Tourism on October 1, 2018. The assessment involved more than 50 percent of stakeholder representation and was conducted with Protected Area (PA) managers, experts, and rangers. Management efficiency of the PAs in the western region increased to 67.08% in 2016, 70.32% in 2018, and 80.30% in 2021. The key values of PAs varied, however, the state of key values was improved due to the annual increase in management efficiency of PAs. In addition, improved efficiency of resource management of the protection administration, regularity of the control and monitoring studies carried out by the rangers, and increasing training and publicity for the public had an impact on the improvement of the state of key values. However, it was observed that the conservation of the key values was also likely affected by nature and climate change.

**Keywords:** *Management effectiveness evaluation, Protected area, Western region, State, Key values to protect*

## Баруун бүсийн ТХГН-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээ

Энхчимэг Цэдэнсодном<sup>1,\*</sup>, Удвал Баярсайхан<sup>1</sup>, Батсайхан Ганбаатар<sup>1</sup>,  
Батдорж Довдондэмбэрэл<sup>1</sup>, Баяртулга Алтанхуяаг<sup>1</sup>

<sup>1</sup>Ойн Нөөц, Ой Хамгааллын Салбар, Газарзүй, Геоэкологийн Хүрээлэн, Шинжлэх Ухааны Академи,  
Улаанбаатар, Монгол

\*Холбоо барих зохиогчийн цахим хаяг: [enkhchimegts@mas.ac.mn](mailto:enkhchimegts@mas.ac.mn)

Хүлээн авсан: 2022 оны 10 сарын 31 өдөр / Зөвшөөрөгдсөн: 2022 оны 11 сарын 30 өдөр / Нийтлэгдсэн: 2022 оны 12 сарын 29 өдөр

### ХУРААНГУЙ

Бид менежментийн үр ашигт байдлын суурь мэдээлэл бүрдүүлэх үнэлгээг БОАЖ-ын Сайдын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/374 тоот тушаалаар батлагдсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний аргачлал”-ыг ашиглан БОЯБХУАӨДЗ төслийн 1-р үе шат хэрэгжсэн улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад хийж гүйцэтгэв. Үнэлгээнд тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН) удирдлага, мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид болон 50 хувиас доошгүй хувийг хамруулав. Үнэлгээнд хамрагдсан баруун бүсийн ТХГН-уудын менежментийн үр ашигт байдал 2016 онд 67.08%, 2018 онд 70.32%, 2021 онд 80.30% болж нэмэгдсэн байв. ТХГН-ийн үнэт зүйлсүүд адилгүй боловч ТХГН-уудын менежментийн үр ашигт байдал жил бүр өсөж хамгааллын үнэт зүйлсийн төлөв байдал ч мөн сайжирсан үзүүлэлттэй байна. Мөн хамгаалалтын захиргааны нөөц боломжийн менежментийн үр ашигт байдал сайжирсан, байгаль хамгаалагчийн хяналт, мониторинг судалгаа тогтмол хийгдэж, иргэд, олон нийтэд хандах сургалт, сурталчилгаа нэмэгдсэн нь хамгааллын үнэт зүйлийн төлөв байдал сайжрахад нөлөөлж байна. Гэвч хамгааллын үнэт зүйлс бэлчээрт байгаль, цаг уурын өөрчлөлт анхаарал татахуйцаар нөлөөлж байна.

*Түлхүүр үгс: Менежментийн үр ашигт байдлын үнэлгээ, Тусгай хамгаалалттай газар нутаг, Баруун бүс, Төлөв байдал, Хамгаалах үнэт зүйл*

### 1. ОРШИЛ

НҮБ-ын “Байгаль орчин ба Хөгжил” сэдэвт Бага хурал 1992 онд зохион байгуулагдсан бөгөөд Монгол улс тогтвортой хөгжлийн анхны илтгэлийг танилцуулж газар нутгийнхаа 30-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах саналыг дэвшүүлсэн байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Тусгай хамгаалалттай газар нутгийг дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэж ангилна. Дээрх үндсэн дөрвөн ангилалд орсон газруудад тохирсон хамгаалалтыг дэглэм, дүрэм, журмуудаар зохицуулна. Мөн эдгээр хамгаалалтын бүсэд байгаа газар нутгуудад төрийн байгууллагын бүрэн эрх: Улсын Их Хурлын бүрэн эрх; Засгийг газрын бүрэн эрх; Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх; Сум, дүүргийг Засаг даргын бүрэн эрх; Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх; Байгаль хамгаалагчийн бүрэн эрхийн хүрээнд явагдана [1].

Тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН) талаарх төрийн бодлогын хэрэгжилтийг хангахын тулд үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлсний дүнд 2020 оны байдлаар нутаг дэвсгэрийн 21 хувь буюу 32.7 сая га газар нутгийг улсын тусгай хамгаалалтад хамруулаад байна. Монгол Улсын Засгийн Газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Германы Сэргээн Босголтын Зээлийн Банкаар (KfW) дамжуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яам “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” (БОЯБХУАӨДЗ) төслийн санхүүжилтээр энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэв [2]. Энэхүү ТХГН-уудын үр ашигт байдлын үнэлгээг хийх нь ТХГН-уудын үр ашигт байдал, хамгааллын үнэт зүйлсийн төлөв байдлыг үнэлж улмаар цаашид үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө боловсруулахад суурь үзүүлэлт болдог. Энэ судалгааны зорилго нь ТХГН-уудын байгаль хамгаалах үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгөхөд оршиж байгаа бөгөөд баруун бүсийн ТХГН-уудын үнэт зүйлсийн төлөв байдлын үнэлэх; ТХГН-уудын биологийн олон янз байдалд учирч буй аюул, дарамтын үнэлэх; ТХГН-уудын менежментийн үр ашигт байдлыг үнэлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэв.

## 2. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

### Судалгаа гүйцэтгэсэн газар

ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээг Отгонтэнгэрийн дархан цаазат газар (ДЦГ); Тарвагатай нуруу, Хангай нуруу, Орхоны хөндий, Хустайн нурууны байгалийн цогцолбор газруудад (БЦГ) гүйцэтгэв (Хүснэгт 1).

### Арга зүй

Менежментийн үр ашигт байдлын суурь мэдээлэл бүрдүүлэх үнэлгээг БОЯБХУАӨДЗ төслийн 1 үе шат хэрэгжсэн баруун бүсийн улсын тусгай хамгаалалттай газруудад БОАЖ-ын Сайдын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/374 тоот тушаалаар батлагдсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний аргачлал”-ыг ашиглав [2; 3].

**Хүснэгт 1.** ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээ хийсэн газрууд

ТХГН-ын статус	Байршил	Газар нутгийн хэмжээ/га
Отгонтэнгэрийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	Отгонтэнгэрийн ДЦГ. Завхан аймгийн Отгон, Алдархаан сум	95,510
	Тарвагатай нурууны БЦГ. Завхан аймгийн Алдархаан, Идэр сум	200,000
Тарвагатай нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа	Тарвагатай нурууны БЦГ. Завхан аймгийн Их Уул, Булнай, Идэр, Алдархаан сум, Архангай аймгийн Цахир сум	332,850.5
Хангайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа	Хангайн нурууны БЦГ Архангай аймгийн Чулуут, Булган, Цэнхэр, Хотонт, Их-Тамир сум	345,227
Орхоны хөндийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа	Орхоны хөндийн БЦГ Архангай аймгийн Хотонт, Хашаат сум, Өвөрхангай аймгийн Уянга, Бат-Өлзий, Хужирт, Хархорин сум	363,636
Хустайн БЦГ-ын хамгаалалтын захиргаа	Төв аймгийн Баянхангай, Аргалант, Алтанбулаг сум	50.6

### Үнэлгээнд хамрагдсан оролцогчдын мэдээлэл

Үнэлгээг оролцогч талуудын төлөөллийн 50-иас доошгүй хувийг хамруулан ТХГН-ийн менежментийг хариуцагч байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчдын оролцоотой хийв. Отгонтэнгэрийн ДЦГ-ын үнэлгээнд 18 хүн оролцоноос хамгаалалтын захиргааны дарга болон мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид 66.6%, орон нутгийн иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, орчны

бүсийн иргэдийн оролцоо 33.4% байна. Эдгээр оролцогчдоос эрэгтэй 44.4%, эмэгтэй 55.6% тус тус байв. Тарвагатай нурууны БЦГ-ын үнэлгээнд 16 хүн оролцсоноос хамгаалалтын захиргаа 76.1%, нутгийн иргэдийн байгууллага болон орчны бүсийн нөхөрлөлүүдийн төлөөлөл 23.8% байв. Үүнээс эрэгтэй 71.4%, эмэгтэй 28.5% байлаа. Хангайн нурууны БЦГ-ын үнэлгээнд 16 хүн оролцсоноос хамгаалалтын захиргааны дарга болон мэргэжилтэн, байгаль хамгаалагчид 31.25%, орон нутгийн захиргаа, ойн анги, орчны бүс, иргэдийн төлөөлөл 56.25% байв. Үүнд эрэгтэй 62.5%, эмэгтэй 37.5% байлаа. Орхоны хөндийн БЦГ-ын үнэлгээнд 15 хүн оролцсоноос хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагчид 66.3%, Хархорин сумын ИТХ-ын дарга, орон нутгийн захиргааны мэргэжилтэн, ТББ-ын тэргүүн, хувийн аж ахуй нэгжийн төлөөлөл, иргэдийн төлөөлөл 33.3% тус бүр байв. Үүнээс эрэгтэй 60%, эмэгтэй 40% байв. Хустайн БЦГ-ын үнэлгээнд 13 хүн оролцсоноос хамгаалалтын захиргаанаас 81.25%, орон нутгийн иргэд, орчны бүсийн зөвлөлөөс 18.75% тус бүр байв. Эдгээр оролцогчдын 69.2% эрэгтэй, 30.7% нь эмэгтэй байв.

### 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

#### 3.1 Үнэлгээнд хамрагдсан ТХГН-уудын үнэт зүйлсийн төлөв байдлын үнэлгээ

Үнэлгээнд хамрагдсан ТХГН-ын үнэт зүйлсийн төлөв байдлын үнэлгээг хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагчдын мониторингийн болон аман мэдээлэлд үндэслэн, 2016, 2018 оны мэдээллийг 2021 онтой харьцуулан гүйцэтгэв. **Отгонтэнгэрийн ДЦГ**-ын төлөөлөл болгон хамгаалахаар сонгосон 5 үнэт зүйлсийн үнэлгээг 2018 оны мэдээллийг харьцуулан үнэлгээг хийв (Хүснэгт 2). 2018 оны менежментийн төлөвлөгөөнд төлөөлөл болгон сонгосон хамгааллын үнэт зүйлсийн экологи, түүх соёл, эдийн засгийн ач холбогдол дээр үндэслэн хэмжээ, нөхцөл, орчны хүчин зүйлс гэсэн 3 шалгуураар талуудын оролцоотойгоор тодорхойлоход, Рашаан ус маш сайн, тахилгат Отгонтэнгэр уулын төлөв байдал болон Ойн сан сайн, Янгир ямаа боломжийн гэж үнэлэгдсэн бол, Алтайн хойлог тодорхойгүй гэсэн үнэлгээтэй гарсан. Хамгаалахаар сонгосон үнэт зүйлс тус бүр дээр нөхцөл байдлын үнэлгээг хийсний эцэст тус УТХГ-ын төлөв байдлын нийлбэр үнэлгээ сайн гэж үнэлэгдсэн байна. Отгонтэнгэр уулын төлөв байдал 2018 онд муу буюу 1-ээр үнэлэгдэж байсан бол 2021 онд сайн буюу 3-аар, Отгонтэнгэрийн рашаан, Улаанхаалганы рашааны төлөв байдал маш сайн, ойн сангийн төлөв байдал сайн, янгир ямаа 2018 онд дунд, 2021 онд сайн буюу 3-аар, Алтайн хойлог 2018 болон 2021 оны үнэлгээгээр сайн буюу 3-аар үнэлэгдсэн бөгөөд өөрөөр хэлбэл, Отгонтэнгэрийн УТХГ-ын өнөөгийн төлөв байдлын нэгдсэн үнэлгээ нь САЙН гэсэн үнэлгээтэй байна [4; 5; 6]. **Тарвагатай нурууны БЦГ**-ын төлөөлөл болгон хамгаалахаар сонгосон 6 үнэт зүйлсийн үнэлгээг 2018 оны мэдээллийг харьцуулан үнэлгээг хийв. Хамгааллын үнэт зүйлийн төлөв байдлын үнэлгээ 2018 оныхоос 1.4-өөр өссөн буюу үнэт зүйлсийн төлөв байдал сайжирсан үзүүлэлттэй үнэлэгдлээ. Төлөөлөл болгон сонгосон үнэт зүйлсийн төлөв байдлыг 2018 оны үнэлгээтэй оноогоор харьцуулсан байдлаар авч үзэхэд ойн сан 1.5, янгир 2, рашаан, булаг шанд 2.0, тарвага 1, алтайн сонгино 2-оор өсөлттэй, харин байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал өмнөх үнэлгээтэйгээ ижил үнэлэгдлээ [7]. **Хангайн нурууны БЦГ**-ын төлөөлөл болгон хамгаалахаар сонгосон 5 үнэт зүйлсийн үнэлгээг 2018 оны мэдээллийг харьцуулан үнэлгээг хийв. Хамгааллын үнэт зүйлийн төлөв байдлын үнэлгээгээр 2018 оныхоос 2-оор буурсан буюу үнэт зүйлсийн төлөв байдал буурсан үзүүлэлттэй үнэлэгдлээ. Төлөөлөл болгон сонгосон үнэт зүйлсийн төлөв байдлыг 2018 оны үнэлгээтэй оноогоор харьцуулсан байдлаар авч үзэхэд шилмүүст ой болон бэлчээр тус бүр 1-ээр буурсан. Түүх, соёлын дурсгал, янгир ямаа болон баданга хүдэр нь өөрчлөлт гараагүй байна. Хамгааллын үнэт зүйлийн төлөв байдлын үнэлгээний 2018 оны дундажтай харьцуулахад 0.4 баллаар буурсан бөгөөд 2021 онд сонгож авсан үнэт зүйлс сайн төвшинтэй үнэлэгдлээ. Мөн шилмүүст ой 1 баллаар, бэлчээр 1 баллаар тус тус буурсан үзүүлэлттэй бол баданга хүдэр, янгир ямаа болон түүх, соёлын дурсгалд өөрчлөлт ороогүй сайн үнэлгээгээр үнэлэгдлээ [8; 9; 10]. **Орхоны хөндийн БЦГ**-ын төлөөлөл болгон хамгаалахаар сонгосон 8 үнэт зүйлсийн үнэлгээг 2018 оны мэдээллийг харьцуулан үнэлгээг хийв. Үнэт зүйлсийн төлөв байдлыг 2018 оны үнэлгээтэй харьцуулахад Түүх соёлын дурсгалууд, Халиун буга, Монгол тарвага 1 дахин нэмэгдсэн байна. Байгалийн үзэсгэлэнт газрууд, Янгир ямааны төлөв байдлын үнэлгээ дунд буюу хэвийн үзүүлэлттэй байна. Харин Шилмүүст ой, Бэлчээрийн, Орхон гол зэрэг үнэт зүйлсийн төлөв байдлын үнэлгээ бага буюу буурсан байна. 2016 оноос хойш хамгааллын арга хэмжээг сайжруулж ирснээр Халиун буга, Монгол тарвага, Түүх соёлын дурсгалуудын төлөв байдлын үнэлгээ эрс нэмэгдсэн буюу сайн гэж үнэлэгдэж байна. Үнэт зүйлсийн ерөнхий төлөв байдлын үнэлгээ 2016 онд аргачлалын дагуу хийгдээгүй бөгөөд 2018 онд 1.9 буюу дундаж, 2021 онд 2 буюу 0.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна [11; 12; 13]. **Хустайн БЦГ**-ын төлөөлөл болгон хамгаалахаар сонгосон 8 үнэт зүйлсийн үнэлгээг 2018 оны мэдээллийг

харьцуулан үнэлгээг хийв. Үнэт зүйлсийн төлөв байдлын үнэлгээнээс харахад Тарвага болон Түүх соёлын дурсгалт зүйлсийн хамгааллын үйл ажиллагаа хоёр дахин нэмэгдсэн байна. Мөн бугын хамгааллын үйл ажиллагаа нэмэгдсэн учраас тоо толгой өсөн нэмэгдсэн байна. Хамгааллын үйл ажиллагаа нэмэгдүүлэх, урт хугацааны төлөвлөгөө хийх шаардлагатай үнэт зүйлс тахь, булаг шанд, ой, хайлаас, бэлчээр байна [14; 15; 16; 17].

**Хүснэгт 2.** Хамгааллын үнэт зүйлсийн үнэлгээ

Үнэт зүйлс	2018 он	2021 он
<b>Отгонтэнгэр</b>		
Отгонтэнгэр уул	1	3
Отгонтэнгэрийн рашаан	4	4
Ойн сан	3	3
Янгир ямаа	3	4
Алтайн хойлог	4	4
<b>Тарвагатайн нуруу</b>		
Ойн сан	2	3.5
Янгир ямаа	2	4
Рашаан, булаг шанд	2	4
Байгалийн өвөрмөгц тогтоц	4	4
Тарвага	3	4
Алтайн сонгино	1	3
<b>Хангайн нуруу</b>		
Шилмүүст ой	4	3
Баданги хүдэр	3	3
Янгир ямаа	3.5	3.5
Түүх, соёлын дурсгал	4	4
Бэлчээр	3	2
<b>Орхоны хөндий</b>		
Шилмүүст ой	1	1
Байгалийн үзэсгэлэнт газрууд	2	2
Орхон гол	2	1
Түүх, соёлын дурсгалууд	3	3
Халиун буга	2	3
Монгол тарвага	2	3
Янгир ямаа	2	2
Бэлчээр	1	1
<b>Хустай</b>		
Тахь	-	2
Буга	-	3
Булаг шанд	-	2
Ой	-	2
Хайлаас	-	2
Бэлчээр	-	2
Тарвага	-	4
Түүх соёлын дурсгалт зүйлс	-	4

### **3.2 Үнэлгээнд хамрагдсан ТХГН-уудын биологийн олон янз байдалд учирч буй аюул, дарамт**

Хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагчдын оролцоотойгоор үнэлгээнд хамрагдсан ТХГН-уудын биологийн олон янз байдалд учирч буй аюул, дарамтыг тодорхойлон гаргав. Аюул, дарамт тус бүрийг (1) хамрах хүрээ, (2) нөлөөллийн хүч, (3) аюул, дарамтыг бууруулах буюу нөхөн сэргээх боломж гэсэн үндсэн 3 шалгуураар үнэлж, 12 бүлэгт багцлан дундаж үнэлгээг гаргав. Аюул, дарамтын үнэлгээнээс харахад ТХГН-уудын экосистем, биологийн олон янз байдлын доройтол, амьдрах

орчны тасархайтал, хомстол бий болоход дараах аюул, дарамт тэргүүлэх зэргийн нөлөө үзүүлж байна (Зураг 1). Үүнд: 1. Бэлчээр ашиглалтын улмаас үүдэлтэй аюул дарамт; 2. Байгалийн системийн өөрчлөлт; 3. Уур амьсгал, байгаль цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй аюул дарамтууд байна.


Отгонтэнгэрийн ДЦГ-ын менежментийн үр ашигт байдлыг 2016 он болон 2018 оны үнэлгээтэй харьцуулж үзэхэд 2018 онд байгалийн нөөцийн хэт ашиглалт, бохирдол, байгалийн системийн өөрчлөлт, өв соёл, нийгмийн өөрчлөлт болон уур амьсгал, байгаль цаг уурын өөрчлөлтөөс аюул дарамт өссөн байхад хүний болон тээвэр үйлчилгээний нөлөөлөл буурсан бол төв суурин газар болон үйлдвэрлэлийн зориулалттай байгууламжаас үүдэлтэй дарамт ижил төвшинд үнэлэгдсэн байна. 2021 оны үнэлгээгээр ОТДЦГ-ын экосистем, биологийн олон янз байдалд учирч буй аюул дарамт өмнөх үнэлгээ хийсэн үеэс 2016 оныхоос 0.1, 2018 оны үзүүлэлтээс 0.8 оноогоор буурсан үзүүлэлттэй байна. Отгонтэнгэрийн ДЦГ-т хамгийн ихээр сөрөг нөлөө үзүүлж буй аюул дарамт нь бэлчээр ашиглалт байна [6].

Тарвагатайн нурууны БЦГ-ын биологийн олон янз байдалд учирч буй аюул, дарамтын 2016 оны үнэлгээг 2021 оныхтой харьцуулахад, бэлчээр ашиглалт, байгалийн системийн өөрчлөлт-экосистемийн үйл ажиллагааг алдагдуулах, байгалийн нөөцийн хэт ашиглалтаас үүдэлтэй аюул, дарамт нэмэгдсэн бол уур амьсгал, цаг уурын өөрчлөлт-урт хугацааны туршид цаг уурын өөрчлөлт болон дэд бүтэц-зэрлэг амьтны амьдрах орчныг дайран гарсан дэд бүтцээс үүдэлтэй аюул, дарамт 2016 оны үеийнхээс багассан байна [7].

Хангайн нурууны БЦГ-ын биологийн олон янз байдалд учирч буй аюул, дарамтын нөлөөллийн дундаж үнэлгээ 2016 онд 1.25, 2018 онд 1.28, 2021 онд 1.26 байгаа бөгөөд Хангайн Нурууны БЦГ-ын экосистем, биологийн олон янз байдалд учирч буй аюул, дарамтын нөлөөллийн хүчийг 2016 оны үзүүлэлттэй харьцуулахад өөрчлөлт гараагүй байна. Төв суурин газар болон үйлдвэрлэлийн зориулалттай байгууламж, уул уурхай, байгалийн системийн өөрчлөлтийн нөлөөллийн хүч нэмэгдсэн бол ойн ашиглалт аюул дарамтын нөлөөллийн хүч буурч, дэд бүтэц, байгалийн бусад нөөцийн хэт ашиглалтаас үүдэлтэй аюул дарамтын нөлөөллийн хүч өөрчлөгдөөгүй байна. Байгалийн цогцолборт газар дотор хамгийн ихээр сөрөг нөлөө үзүүлж буй аюул дарамт нь ой ашиглалт болон бэлчээр ашиглалт байна [10].

Орхоны хөндийн БЦГ-ын 2018 онд хийсэн үнэлгээнээс харахад уул уурхай, дэд бүтэц, бэлчээр ашиглалт, төв суурин газар болон үйлдвэрийн зориулалттай газрууд илүү аюул дарамт үзүүлж байв. Үүнийг 2021 оны үнэлгээтэй харьцуулахад аюул дарамтын хэмжээ харьцангуй буурч улмаар 2016 оны үнэлгээнээс буурсан байлаа. ОХБЦГ-т бэлчээр, газар тариалан, бохирдолт ба өв соёл, нийгмийн өөрчлөлтөөс үүсэх аюул дарамтууд нь 2 оноотойгоор дунд зэрэг хэмээн үнэлэгдсэн байна. Жил бүр Хархорин сумын Ус цаг уурын салбараас хийдэг судалгааны үр дүнгээс харахад Хашаат, Хотонт, Хужирт, Хархорин сумдад бэлчээрийн талхигдал 1-3 дахин (нийт ТХГН-ийн 20-30%) байгаа болон 2021 онд Хотонт, Хашаат, Хархорин сумдын нутгийн бэлчээрт хортон мэрэгчийн тархалт ихэссэн бөгөөд ашигт ургамлын зүйлийн бүрдэл цөөрсөн зэргээс шалтгаалан бэлчээр ашиглалтаас үүсэх аюул дарамт 2 оноотойгоор дунд гэж үнэлэгдсэн. Ой бүхий сумдад ойн хортон шавж, өвчлөл их байдаг ба хортон устгалын талбайн хэмжээнд төсөв хүрэлцдэггүй тул шаардлагатай хэмжээнд устгал явуулж чаддаггүй байна [13].


Хустайн БЦГ-ын 2016 оны үнэлгээнд бэлчээр ашиглалтыг цаг агаар хүндэрсэн жилүүдэд орчны бүсийн мал ТХГН-д орж ирсний улмаас бэлчээрийн талхигдал бага зэрэг үүсдэг гэж үнэлсэн байна. 2019, 2021 оны үнэлгээгээр бэлчээр ашиглалт хамгийн өндөр аюул дарамттай үнэлэгдэв. Хустайн БЦГ-ын 95% буюу 48345 га газрыг бэлчээрт ашиглагдах боломжтой гэсэн тооцоо байдаг. Гэтэл сүүлийн жилүүдэд хамгаалалттай газрын хил дагуух айл, малчдын өвөлжөө, хаваржаа олширч, малын тоо толгой хэт өсөж, төвлөрснөөр орчны бүсийн бэлчээрийг талхалж ургац буурснаас олон тооны мал хамгаалалттай газрын бэлчээрлэх нь нэмэгдсэн. Хамгаалалттай газарт мал байнгын бэлчээрлэх болсон нь зэрлэг амьтад бэлчээр нутгаар шахагдаж, хамгаалалттай газрын төв хэсэгт хэт төвлөрч байрших болсонтой холбоотой [17].



**Зураг 1.** ТХГН-ын экосистем, биологийн олон янз байдалд учирч буй аюул, дарамтын харьцуулсан үзүүлэлт


### 3.3 Үнэлгээнд хамрагдсан ТХГН-уудын менежментийн үр ашигт байдал

Үнэлгээнд хамрагдсан ТХГН-ын менежментийн үр ашигт байдлыг илэрхийлэх шалгуур үзүүлэлт бүхий үндсэн 6 бүлэг, 13 төрөлд хамаарах 53 (нэмэлт 4 асуултын хамт) асуулгаар үнэлэв. Үнэлгээнд хамрагдсан ТХГН-уудын менежментийн үр ашигт байдал дунджаар 2016 онд 67.08 хувь, 2018 онд 70.32 хувь, 2021 онд 80.30 хувьтай байв (Зураг 2). Үүнээс харахад үнэлгээнд хамрагдсан ТХГН-уудын менежментийн үр ашигт байдал жил тутам нэмэгдэж, үйл ажиллагааны чиглэлүүд сайжирсан байна.




**Зураг 2.** ТХГН-ын менежментийн үр ашигт байдал

Үнэлгээний дүнг үндсэн 6 бүлэгт хамаарах шалгуур үзүүлэлтээр нэгтгэж үзэхэд (1) хууль эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт, (2) төлөвлөлт, (3) нөөц боломж, (4) бодит үйл ажиллагаа, (5) үнэлгээ мониторинг, (6) үр ашиг 45-ээс дээш хувьтай байна (Зураг 3).



Зураг 3. ТХГН-ын менежментийн үр ашигт байдал (үнэлгээ хийсэн онуудаар)


Хамгаалалтын захиргааны нөөц боломж, менежментийг хариуцагчийн байгууллагын бүтэц, хүний нөөцийн үр ашиг 2016 онд 76.66 хувь, 2018 онд 75.01 хувь, 2021 онд 88.7 хувь, ажлын байр, техник тоног төхөөрөмжийн хангамжийн менежментийн үр ашигт байдал 2016 онд 63.3 хувь, 2018 онд 69.21 хувь, 2021 онд 86.7 хувь, ТХГН-ийн санхүүжилт 2016 онд 53.34 хувь, 2018 онд 62.3 хувь, 2021 онд 73.3 хувь байна (Зураг 4). Нийт дүнгээр Хамгаалалтын захиргааны нөөц боломжийн менежментийг хариуцагчийн байгууллагын бүтэц, хүний нөөцийн үр ашиг 80.12 хувь, ажлын байр, техник тоног төхөөрөмжийн хангамжийн менежментийн үр ашигт байдал 73.05 хувь, ТХГН-ийн санхүүжилт 62.95 хувь байна. Эдгээр үзүүлэлтүүд үнэлгээ хийгдсэн жилүүдэд сонгогдсон ТХГН-ийн нөөц боломж нэмэгдсэн байна.



Зураг 4. ТХГН-ийн нөөц, боломжийн менежментийн үр ашигт байдал

Бодит үйл ажиллагааны хувьд 2016 онд 56.57 хувь, 2018 онд 67.64 хувь, 2021 онд 77.9 хувь буюу үнэлгээ нэмэгдсэн байна. Үүнээс эдгээр ТХГН-уудад судалгаа шинжилгээ, мэдээллийн сан бүрдүүлэлтийн үйл ажиллагаа нэмэгдсэн буюу 78.9 хувь, мэдээлэл харилцаа, сургалт, сурталчилгаа 72.3 хувь хамгийн өндөр байна. Харин аялал жуулчлал 62 хувь, ТХГН-ийн орчны бүсийн менежмент 61.5 хувь тус тус хамгийн бага үнэлэгдэв (Зураг 5) [6; 7; 10; 13; 17].





Зураг 5. Бодит үйл ажиллагааны менежментийн үр ашигт байдал

#### 4. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Германы Засгийн газар ба KfW хөгжлийн банкны санхүүжилтээр 2016 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн “Биологийн олон янз байдлын суурь мэдээлэл бүрдүүлэх судалгаа”-г 15 тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны оролцоотой гүйцэтгэсэн байна. Уг судалгаанд ТХГН-уудын хамгааллын үнэт зүйлсэд хамаарах 13 зүйл амьтан, нэмэлт 6 зүйлийн амьтдын төлөв байдлын үнэлсэн байна. Судалгаанаас харахад зорилтот амьтдын тархалт, нягтшил ТХГН тус бүрд харилцан адилгүй байгааг харгалзан үзэх шаардлагатай байна. Гэвч нийт газар нутгуудад амьтдын нягтшилд нөлөөлж буй хүчин зүйлс; бэлчээрийн давхцал, ган зуд, амьдрах орчны доройтол зэрэг нийтлэг шинж чанартай байна. Мөн хүний оролцоотой сөрөг нөлөө хууль бус агнуур, самар жимс хэтрүүлэн бэлтгэх, түймэр зэрэг байна [18]. 2018 онд хийсэн ТХГН-ийн үнэлгээний тайлангаас харахад ТХГН-ийн хамгааллын үнэт зүйлсийн төлөв байдалд сайн, хамгааллын үнэт зүйлсэд нөлөөлж байсан хууль бус агнуур, хүний оролцоотой гарч байсан түймрийн тоо, хулгайгаар самар, жимс бэлтгэх үйл ажиллагааг бууруулсан байна. 2021 онд хийсэн бидний үнэлгээгээр хамгааллын үнэт зүйлсийн төлөв байдал эрс сайжирсан байлаа. Гэвч уур амьсгалын өөрчлөлтөөс бэлчээрийн доройтолд өртөж байна. Мөн малын тоо толгой нэмэгдэж, зэрлэг амьтадтай бэлчээрийн давхцал нэмэгдэж байгаа нь бэлчээрийн доройтлыг эрчимжүүлж байна [19].

ТХГН-уудын менежментийн үр ашигт байдал 2016 онд 67.08%, 2018 онд 70.32%, 2021 онд 80.30% байв (Зураг 2). Менежментийн үр ашигт байдал жил бүр нэмэгдэж байгаа нь ТХГН-уудад хэрэгжиж буй төслийн санхүүжилт, үйл ажиллагааны тогтвортой төлөвлөгөө бий болсонтой холбоотой байна. Мөн орчны бүсийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ТХГН-уудын үйл ажиллагааны үндсэн зорилгыг таниулах чиглэлд анхаарч ажилласан нь хамгааллын үнэт зүйлс, менежментийн үр ашигт байдал нэмэгдэхэд сайн нөлөөтэй байна.

#### 5. ДҮГНЭЛТ

Үнэлгээний дүнгээс харахад оноо бага байх эсвэл буурахад дараах хүчин зүйлс голлон нөлөөлж байна.

ТХГН-ын хамгааллын үйл ажиллагаа сайжирсан тул үнэт зүйлсийн үнэлгээ сайжирч байна. Гэвч бэлчээрийн зүй зохисгүй ашиглалт, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ойн нөөцийн бууралт болон бэлчээрийн доройтол ТХГН-ын үнэт зүйлсэд нөлөөлж байна.

Ихэнх ТХГН-уудад зэрлэг амьтад болон малын бэлчээрийн давхцал өндөр байна. Малын бэлчээрлэлтээс болж зэрлэг амьтдын бэлчээрийн хуваарьт өөрчлөлт орж, нэг газраа ихэвчлэн төвлөрөл үүсгэх хандлагатай байгаа нь халдварт өвчин тархах эрсдэлтэй байна.

Ихэнх ТХГН-уудад бэлчээр, газар ашиглалттай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт зөрчилддөг хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

Хамгаалалтын захиргааны төсөв тогтвортой байдаг боловч менежментийн үр ашгийг дээшлүүлэх, хамгааллын үйл ажиллагааг сайжруулах, бусад менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг хийж гүйцэтгэхэд хүрэлцээ муу байна.

ТХГН-уудад ХБНГУ-ын Сэргээн босголт банкны санхүүжилтээр хэрэгжсэн менежментийн үр ашгийг дээшлүүлэх төслийн дагуу байгаль хамгаалагчдын постууд, хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, хамгааллын захиргааны байраар хангаж өгсөн нь үр ашиг нэмэгдэхэд чухал нөлөөтэй байна.

Хүний нөөц, мэргэжилтэн байгаль хамгаалагчдын идэвх, чадавх нэмэгдсэн, мөн бэлчээр хамгаалах, түймрийн эрсдэлийг бууруулах чиглэлээр орчны бүсийн иргэд мэдээлэл өгөх оролцоо нэмэгдсэн байна.

Орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, экологийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр байгаль хамгаалах идэвх, санаачилгыг нэмэгдүүлж ажиллаж байна.

Судалгаа, мониторинг, мэдээллийн сангийн бүрдүүлэлт хангалттай сайн хийгдэж байна.

Үнэлгээ, мониторингийн системийн үйл ажиллагаа сайжирч байна.

## ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг Монгол Улсын Засгийн Газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Германы Сэргээн Босголтын Зээлийн Банкаар (KfW) дамжуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яам “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” (БОЯБХУАӨДЗ) төслийн санхүүжилтээр гүйцэтгэсэн бөгөөд төслийн хамт олонд талархал илэрхийлье.

## АШИГЛАСАН НОМ, ХЭВЛЭЛ

- [1] Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай (<https://legalinfo.mn/mn/detail/479>). 1994
- [2] Б. Мөнхчулуун, Л. Галрагчаа. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний арга зүй. Улаанбаатар, 2018
- [3] Хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний аргачлал, Улаанбаатар, 2018.
- [4] Отгонтэнгэр УТХГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээний тайлан, Улаанбаатар, 2016
- [5] Отгонтэнгэр УТХГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээний тайлан. Улаанбаатар, 2018
- [6] Отгонтэнгэрийн ДЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээний тайлан. ШУА, Газарзүй, геоэкологийн хүрээлэн. Улаанбаатар, 2021
- [7] Тарвагатайн нурууны БЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээний тайлан. ШУА, Газарзүй, геоэкологийн хүрээлэн. Улаанбаатар, 2021
- [8] Хангайн Нурууны БЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээ. Улаанбаатар, 2018
- [9] Хангайн Нурууны БЦГ-ын менежментийн төлөвлөгөө (2019-2022). Улаанбаатар, 2018
- [10] Хангайн нурууны БЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээний тайлан. ШУА, Газарзүй, геоэкологийн хүрээлэн. Улаанбаатар, 2021
- [11] Орхоны хөндийн БЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээ. Улаанбаатар, 2016
- [12] Орхоны хөндийн БЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээ. Улаанбаатар, 2018

- [13] Орхоны хөндийн БЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээний тайлан. ШУА, Газарзүй, геоэкологийн хүрээлэн. Улаанбаатар, 2021
- [14] Хустайн БЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээ. Улаанбаатар, 2016
- [15] Хустайн БЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээ. Улаанбаатар, 2019
- [16] Хустайн БЦГ-ын хамгаалалтын захиргааны жилийн үйл ажиллагааны тайлан 2012-2020 он. Улаанбаатар, 2020
- [17] Хустайн БЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээний тайлан. ШУА, Газарзүй, геоэкологийн хүрээлэн. Улаанбаатар, 2021
- [18] Биологийн олон янз байдлын тухай конвенцын үндэсний VI тайлан (2015-2018). БОАЖЯ. Улаанбаатар, 2019
- [19] “Тусгай хамгаалалттай газар нутгуудын менежментийн үр ашигт байдлын шалгуур үзүүлэлтэд мониторинг, үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний тайлан (Баруун бүс). ШУА, Газарзүй, геоэкологийн хүрээлэн. Улаанбаатар, 2021